



**ШУДАРГА ЁС ХӨГЖИЛ ДЭВШИД
ХАМТДАА АЯН-2023**

АВЛИҮН ЭСРЭЛ

...НЭГДЭЕ © ППО

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТЭС**

ШУДАРГА ЁС ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 07 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар №01

Мандалговь хот

Дундговь аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулж байгаа “Шударга ёс хөгжил дэвшилд хамтдаа” аянд тус аймгийн Татварын хэлтэс 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ны өдрийг дуусах хүртэл хугацаанд идэвхтэй оролцлоо.

1. Аяны хүрээнд байгууллагын албан хаагчдаа уриалж Мэдээллийн аюулгүй байдал, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Байгууллагын нууцын тухай сэдэвт сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.







Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 49 дүгээр тогтоол, АЗДТГ, ТЕГ, АТГ-ын зөвлөмж зэргийг үндэслэн 3 зорилт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан дагуу дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав.

"Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын тогтоол, "5Ш" хөтөлбөр, "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчид хүргэн сурталчлах, Засгийн газар, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллах зорилтын хүрээнд ТЕГ-т 1 удаа, АЗДТГ-т 1 удаа хүний нөөцийн судалгааг өгөгдсөн хүснэгийн дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд татварын албаны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, их өгөгдлийн санд суурилсан албан хаагчийн томилгоог хийх, төрийн

байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээний хүрээнд төрийн албаны хүнийн нөөцийн hrm.csc.gov.mn системд 27 албан хаагчийн мэдээллийг тухай бүрт шинэчилсэн. Тайлант хугацаанд 1 албан хаагч ерөнхий болон тусгай шалгалтыг өгөн тэнцэж томилогдон ТА3-ийн дүгнэлтийг үндэслэн холбогдох материалын ТЕГ-т хүргүүлэн жинхлэн томилогдсон. Сул орон тооны захиалыг ТАС3-д 2 удаа хүргүүлсэн. Ямар нэгэн зөрчилтэй томилгоо гаргаагүй.


Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Дундговь аймгийн татварын хэлтэс пэйж хуудсаар нийт 4 пост, 6 шэйр байршуулж 632 иргэнд түгээсэн байна. Хэлтсийн байранд самбар байршуулан мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласан.



2.ТХШ-ийн тасгийн 3 албан хаагч 16 удаагийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийн шалгаж буй 7 байгууллага шалгах явцдаа гаргасан.

3.Нийт ХАСХОМ, ХАСУМ гаргадаг 19 албан хаагчид 2 удаа сургалт зохион байгуулсан.

4.ТЕГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүй цахим сургалтад нийт албан хаагчид 100 хувь хамрагдсан.



Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахдаа Худалдан авалтыг нийт 18 байгууллагатай хамтран ажиллах гэрээнд заалтыг тусган хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх, Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээний хүрээнд Татвар төлөх КИОСК машин АЗДТГ-ийн дэмжлэгээр авч хэлтэст байршуулан, цахимаар татвар төлөх боломжийг илүү нэмэгдүүлж татвар төлөгчид таатай нөхцөлийг бүрдүүлсэн 2.АЗДТГ санхүү төрийн сангийн хэлтэс, ТИНЗ, МНБИ-тэй хамтран 1 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. 3.Татвар төлөгчдөөс цахим хуудсаараа дамжуулан санал асуулгыг авч нэгтгэсэн. 1.Төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ТЕГ, АЗДТГ-т хүргүүлсэн 2. АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн 3 заалтыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусган батлуулж, цахимаар 4 пост байршуулан 258 иргэнд танилцсан байна





ХЯНАСАН: ТАСГИЙН ДАРГА *Ш.Мөнхтүвшин* /Ш.МӨНГӨНЦЭЦЭГ/

/гарын үсэг/

/овог, нэр/

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛИЙН ЗӨВЛӨХ *М.Ууганцэцэг* /М.УУГАНЦЭЦЭГ/

/гарын үсэг/

/овог, нэр/